



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Бодлогын зөвлөл, түүний журмыг шинэчлэхтэй холбогдуулан зарим арга хэмжээ авах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус Хорооны дэргэд байгуулагдсан Бодлогын зөвлөлүүдийн дарга, гишүүдийг шинээр томилох, шинэ зохион байгуулалтад оруулах, ажиллах журмыг шинэчлэхтэй холбогдуулан тухайн салбарын Бодлогын зөвлөлийг мэргэжлийн холбоод, байгууллага, судлаачид болон хөндлөнгийн байр сууринаас оролцох этгээдүүдийн төлөөллөөр бүрдүүлэх, Бодлогын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулахыг Хорооны гишүүдэд даалгасугай:

- | | |
|------------------|---|
| 1/ Э.Батболд | Даатгалын бодлогын зөвлөлийн; |
| 2/ Ж.Цэдэнрагчаа | Үнэт цаас /хөрөнгийн/-ны зах зээлийн бодлогын зөвлөлийн; |
| 3/ Д.Ганбат | Банк бус санхүүгийн салбарын бодлогын зөвлөлийн; |
| 4/ Л.Энхтайван | ХАА-н биржийн хөгжлийн бодлогын зөвлөлийн; |
| 5/ Д.Ганбаяр | Уул уурхай, эрдэс баялаг, түүхий эдийн биржийн хөгжлийн бодлогын зөвлөлийн; |
| 6/ Х.Бум-Эрдэнэ | Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогын зөвлөлийн. |

2. Бодлогын зөвлөлийн ажиллах журмын төслийг дээрх гишүүдээс гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэх замаар шинэчлэн боловсруулан уг Зөвлөлүүдийг Хорооны дэргэдэх нэгж болгон байгуулах шийдвэрийн төслийн хамт 2015 оны 02 дугаар сарын Хорооны хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Тамгын газрын Эрх зүйн хэлтэс /О.Батбилэг/-т даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000678